



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/333

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн ихэнх нутгаар салхи шуурга ихтэй, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан малчин өрхүүдэд зориулж мал хамгаалах зорилгоор “Тосонбүргэдэй” ХХК –аас малын нэмнээ хийх материал худалдан авсан зардалд 7,000,000 (долоон сая төгрөг)-ийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг Мал хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Сумдад хуваарилсан нэмнээ хийх материалын үнийг 2023 оны 11 дүгээр сарын 01 ний өдрийн дотор мал хамгаалах санд төвлөрүүлэхийг мал хамгаалах сангийн нярав (Б.Эрдэнэбилэгт)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болсугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР

